

Издан 1993 оны А-182г Засиралдах
хүчинчийн.

78



БИМАУ
УЛААНБААТАР ХОТЫН АРДЫН ХУРЛЫН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ ТОГТООЛ

1991 оны 10 сарын 27.

№ 25

Улаанбаатар
хот

Хөдөлмөр, нийгэм хангамжийн
албадын бутэц, зохион бай-
гуулалтыг өөрчлөх тухай

Улаанбаатар хотын Ардын Хурлын гүйцэтгэх захиргаанаас
ТОГТООХ нь:

1.Хотын Ардын Хурлын гүйцэтгэх захиргааны Хөдөлмөр, нийгэм
хангамжийн халтэс, хотын хөдөлмөр эрхлэлтийн газраг татан буул-
гаж, хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн хяналт, нийгэм хангамж, нийг-
мийн даатгалын асуудлыг нэгтгэн хариуцах үүрэг бүхий Хөдөлмөрийн
газар байгуулсугай.

2.Хөдөлмөрийн газрын дүрмийг хавсралт ёсоор баталсугай.

3.Хөдөлмөрийн газар байгуулсантай холбогдуулан Хотын хянан
байцаах албанд ажиллах байгаа хөдөлмөр хамгааллын улсын 5 бай-
цаагчийг сарын цалингийн сан 8,0 мянган төгрөгийн хамт тус газарт
шилжүүлж хөдөлмөрийн улсын байцаагчаар ажилдуулсугай.

4.Хөдөлмөрийн газрын сарын цалингийн санг 22,5 мянган төг-
рөгөөр баталж, үүнээс 9,0 мянган төгрөгийн цалингийн санг ажил
эрхлээгүй хүмүүст дэмжлэг үзүүлах хотын сангаас санхүүжүүлж бай-
хаар тогтоосугай.

5.Энэ тогтоол гарсантай холбогдуулан Улаанбаатар хотын Ардын
Хурлын гүйцэтгэх захиргааны "Хөдөлмөр эрхлэлтийн газар байгуулах
тухай" 1991 оны 65 дугаар тогтоол, "Дүрэм батлах тухай" 1991 оны
86 дугаар тогтоолын 7 дугаар хавсралт, "Аппаратын бүтэц, орон
тоо, цалингийн тухай" 1991 оны 16 дугаар тогтоолын I дүгээр заал-
тын "... хүн ам зүй, хөдөлмөрийн хэлтсийг Хөдөлмөр, нийгэм хан-
гамжийн халтас..." гасан хэсгийг тус тус хүчингүй болсонд тооц-
сугай.

УЛААНБААТАР ХОТЫН АРДЫН
ХУРЛЫН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИР-
ГААНЫ ДАРГА

ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА.

Л. ЭНЗБИШ

Ц. БОЛДСАЙХАН



Улаанбаатар хотын Ардын Хурлын ГҮЙ-
ЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ 1991 ОНЫ 3/5
ДУГААР ТОГТООЛЫН ХАВСРАЛТ

УЛААНБААТАР ХОТЫН ХӨДӨЛМЕРИЙН ГАЗРЫН
ДҮРЭМ

НЭГ. НИЙТЛҮҮГ ҮНЭСДЭЛ

1. Хөдөлмөрийн газар нь хөдөлмөрийн нөөц, ажиллах хүчийг оновчтой ашиглах, хөдөлмөрийн чадвартай иргэн бүрийн хөдөлмөрлөх эрхийг бүрэн хангах, хөдөлмөр эрхлэлт, нийгэм хангамж, нийгмийн даатгалын асуудлаар төрийн зүгээс явуулж байгаа бодлогыг хөрөгжүүлэх, энэ талаар холбогдох арга хэмжээг зохион байгуулах, хотын хэмжээнд хөдөлмөрийн улсын хяналтыг хөрөгжүүлэх ажлыг эрхлэх зорилт бүхий орон нутгийн төрийн захиргааны байгууллага болно.

2. Хөдөлмөрийн газар нь БНМАУ-ын хөдөлмөрийн хууль, Тэтгэврийн хууль, Тэтгэмжийн хууль болон хөдөлмөр эрхлэлт, нийгэм хангамж, нийгмийн даатгал хөдөлмөрийн хяналтын талаар Засгийн газар, Хөдөлмөрийн яам, хотын АХ-ын гүйцэтгэх захиргааны тогтоол, захирамж, түүнчлэн энххүү дурмийг удирдлага болгон ажиллана.

3. Хөдөлмөрийн газар нь хотын АХ-ын гүйцэтгэх захиргааны үндсэн нэгж бөгөөд түүний өмнө ажлаа хариуцаж тайлагнана.

4. Газар нь хуулийн этгээдийн эрх эдэлж, уургэг гүйцэтгэх бөгөөд эрх хэмжээнийхээ асуудлаар тушаал гаргана. Түүнчлэн тогтоогдсон журмаар хийгдсэн тэмдэг хөрөглэх ба харилцах данстай байна.

5. Газрын даргыг томилох, өөрчлөх асуудлыг хотын АХ-ын гүйцэтгэх захиргааны хурлаар шийдвэрлэнэ.

ХӨӨР. Газрын үүрэг

Хөдөлмөр нийгэм хангамжийн газар нь дараах уургийг гүйцэтгэнэ.

I. Хөдөлмөр эрхлэлтийн газар

а/ Улаанбаатар хотод хөдөлмөр эрхлэлтийн талаар хэтийн болон ойрын жилүүдэд баримтлах чиглэл, бодлого боловсруулж, түүнийг хөрөгжүүлах талаар холбогдох арга хэмжээ зохион байгуулах.

б/ Хотын хөдөлмөрийн нөөцийн ашиглалт, ажиллах хүчиний эрэлт хөрөгцээ нийлүүлэлт, хуваарилалтын байдлыг судалж, хөдөлмөрийн нөөцийн төлөвлөгөөг болон гүйцэтгалийн тэнцэл зохиох, холбогдох дүгнэлт, санал боловсруулах.

в/ Хөдөлмөр эрхлээгүй иргэдийн болон ажлын байрны тухай мэдээллийг хотын хэмжээнд нэргэх, дуургийн хөдөлмөрийн захуудад

мэдээлэх шаардлагатай статистикийн тайлан мэдээг гаргах.

г/ Ажиллах хүчний зах зээлийг нарийн судалсан үндсэн дээр мэргэжилтэй ажилчид бэлтгэх, давтан сургах, ажилчдын мэргэжлийг дээшлүүлэх асуудлаар баримтлах чиглэлийг тодорхойлох, энэ үндсан дээр сургалт зохион байгуулах.

д/ Гадаад орнуудад ажиллах хүч гаргах асуудлаар судалгаа хийж, холбогдох улс, байгууллагуудтай гэрээ хэлэлцээр байгуулах, ажиллах хүч гаргах, ажиллах хүч дутагдалтай аймаг, хотуудад ажилчны малчныг зохион байгуулалттай элсүүлах, шилжүүлах.

ж/ Дүүргүүдийн хөдөлмөрийн захыг арга зүйн удирдлагаар хангаж, мэргэжилтэй боловсон хүчинээр бэхжүүлах, тэдний мэргэжлийг нь дээшлүүлэхэд туслалцаа үзүүлэх.

2. Нийгэм хангамжийн талаар

а/ Татгэвэр тэтгэмжийн холбогдолтой хууль, тогтоомжийг хэрэгжүүлэх, биелэлтэд нь хяналт тавьж ажиллах.

б/ Иргэдэд тэтгэвэр тэтгэмж тогтоохтой холбогдсон баримтыг бурдугулах ажлыг хотын үйлдвэр байгууллагуудад зохион байгуулах, тэтгэвэр тогтоох орон тооны бус байнгын комисс, нийгэм хангамжийн ажилтнуудыг нэгдсэн болон арга зүйн удирдлагаар хангах.

в/ Тэтгэврийн санг хот, дүүргийн хэмжээнд төлөвлөж хуваарилах, зарцуулалтад хяналт тавих, энэ талаар тайлан тэнцлийг шалгах хулээн авах.

г/ Өндөр настай, тахир дутуу иргэдэд тавих анхаарал, халамжийг дээшлүүлэх, хөнгөлөлт туслалцаа үзүүлэх, зориулалтын тээврийн хөргөсөл олгох хиймэл эрхтэн хийлгэх, мэргэжил эзэмшиүүлэх зэрэг ажлыг зохион байгуулах.

3. Нийгмийн даатгалын талаар

а/ Улсын нийгмийн даатгал, амралт сувиллын асуудлаар төрийн дээд байгууллагуудын шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг хотын хэмжээнд нэгдсэн удирдлагаар хангаж зохион байгуулах.

б/ Нийгмийн даатгалын жил, улирлын төсвийг байгууллага бүрээр зохиож, төсвийн орлого, зарлагын гүйцэтгэлд хяналт тавьж, үйлдвэр, байгууллага, хоршоо, пүүс, хувь хумүүсээс төлөх нийгмийн даатгалын шимтгэлийг хугацаанд нь тооцож оруулах ажлыг зохион байгуулах.

в/ Уйлдвэр, байгууллага, хоршоо шүүс, хувь хүмүүстэй шимтгэл төлөлт, тэтгэмж олголтын тайланг улирал бүр авч, тооцоо нийлэх, эр авлагыг барагдуулах, баримтын шалгалт хийж, зөрчил төлбөрийн акт тогтоох.

4. Хөдөлмөрийн улсын хяналтын талаар

1. Хөдөлмөрийн хууль тогтоомж, Засгийн газрын холбогдох тогтоол шийдвэр, хөдөлмөрийн стандартын биелэлтэд хяналт тавьж хэрэгжүүлэх.

2. Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, хөдөлмөр хамгаалал, хөдөлмөрийн хөлс, хамтын болон хөдөлмөрийн гэрээ, хөдөлмөрийн сахилга, ажил, амралтын цагийн горим, ажиллах хүчиний ашиглалттай холбогдсон ўйл ажиллагааны хуреэнд илэрсэн зөрчил, дутагдлыг шуурхай арилгуулах, учирсан хохирлыг нөхөн төлүүлах, дахин гаргуулахгүй байх ажлыг зохион байгуулах.

3. Хөдөлмөрийн улсын хяналтын талаар байгууллагын дарга, эзэн, ажилчдад техникийн мэдээлэл, зөвлөлгөө өгөх, сургалт явуулах.

1/УРАВ. Газрын эрх

Хөдөлмөрийн газар нь дор дурдсан эрх эдлэнэ.

а/ Хөдөлмөр, нийгэм хангамж, нийгмийн даатгалын холбогдолтой асуудлаар мэдээ, судалгаа, шаардлагатай материалыг дүүрэг, хороод болон албан байгууллага, Уйлдвэр аж ахуйн газраас гаргуулж авах.

б/ Дүүргүүдийн хөдөлмөр, нийгэм хангамжийн хэлтэс, хөдөлмөрийн захуудын ажлыг шалгаж танишах, үүрэг даалгавар өгөх.

в/ Бүх төрлийн байгууллага, Уйлдвэр аж ахуйн газруудын эрх баригчдаас гаргасан тушаал шийдвэр нь хөдөлмөр эрхлэлт, нийгэм хангамж, нийгмийн даатгал, хөдөлмөрийн улсын хяналтын холбогдолтой хууль, тогтоомжинд харшиг байвал түүнийг биелүүлэхийг зогсоож өөрчлүүлэх тухай саналлаа төрийн зохих байгууллагад тавьж шийдвэрлүүлэх.

г/ Өмч аж ахуйн хэлбэрээс үл хамааран бүх төрлийн байгууллага, Уйлдвэрийн газар, хоршоо, компаниас ажлын чиглэлээр хийж байгаа өөрчлөлт, авч байгаа арга хэмжээний талаар мэдээлэл авах, ажлын чөлөөтэй байр өйгээ нөхцөлд зохих мэргэжлийн кумуусийг шилжүүлэх ажлыг зохион байгуулах.

д/ Улсын Уйлдвэрийн газар, хувиараа эрхлэх аж ахуй, хоршоо, компани, иргэдтэй урьдчилан тохиролцсоны үндсэн дээр тэднийг төлөөлж ажилчин элсүүлах, сургалт явуулах, эргэн төлөгдөх хэлбэрээр зээл олгох.

4.

е/ Тэтгэврийн сан, нийгмийн даатгалын хөрөнгө, ажилгүй хүмүүст туслах үзүүлэх, ажлын байр бий болгох сан, бага орлоготой хүмүүст тэтгэмж олгох санг төсөв төлөвлөгөөний дагуу зарцуулах, хуваарилах.

ж/ Бүх төрлийн тэтгэвэр тэтгэмжийн олголт, тогтоолын материал, нийгмийн даатгалын хөрөнгийн зарцуулалт, хөдөлмөр хамгааллын байдлыг байгууллага, иргэд дээр шалгах, илэрсэн зөрчилд зохих тorgууль ногдуулах, шаардлагатай үед хуулийн байгууллагаад шилжүүлэх.

УЛДААНБААТАР ХӨЧИН АХ-ЫН ГҮЙЦЭЛГЭХ
ЗАХСРГАА